



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 04 сарын 10 өдөр

Дугаар A/51

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Өргөх тавцантай автомашин авах Орон нутгийн хөрөнгө оруулалтын 3.1-д тусгагдсан 38.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын
ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: Б.Баяржаргал - Зооноз өвчин судлалын төвийн дарга
О.Дариймаа - Төрийн бус байгууллагын төлөөлөл
Ж.Ганболд - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн

дарга: Х.Дэмид - Орон нутгийн өмчийн газрын Худалдан
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ц.Даваасамбуу/-нд даалгасугай.

3.Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2020 Тг А/51-Сх
02 00293